**НИЙГМИЙН УХААНЫ 11-Р АНГИЙН ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

**ХУГАЦАА: 80 МИНУТ**

**НИЙТ ОНОО: 40**

**А хувилбар**

1. **Ангийн ялгаа эрүүл мэндийн үйлчилгээ авах үйлдэл, хандлагын ялгаанд хүргэдэг болохыг нотолсон судлаач хэн бэ?Р**
   А. Ө. Күүс Б. Д.Датон В. Л.Козер Г. Е.О. Райт

2. **Нийгмийн гишүүд хувийн шинжээрээ зааглагдан хуваагдахыг юу гэдэг вэ?**
   А. Нийгмийн ялгарал Б. Тэгш бус байдал В. Нийгмийн давхраажилт
   Г. Нийгмийн давхраа
3. **Материаллаг баялгийн хэмжээ, эрхэлж буй ажил мэргэжлээр тодорхойлогддог, аж үйлдвэржилтийн харилцааны үр дүнд тогтсон, эдийн засгийн баялгийн ялгаанаас үүдэлтэй, харьцангуй нээлттэй буюу хувийн байр сууриа өөрчлөх боломжтой давхраажилтын хэв маяг аль нь вэ?**
   А. Боолчлол Б. Каст В. Язгуур угсаа Г. Анги бүлэг
4. **Тун бага хувийг эзэлдэг ч баялгийн дийлэнхийг эзэмшдэг. Энэ ангийн байр суурь нь үе залгамжилдаг гэсэн нь ямар ангийн талаар мэдээлэлж байна вэ?**
   А. Доод анги Б. Ядуу ажилчин анги В. Дээдийн дээд анги
   Г. Дундын дунд анги
5. **Нэг бүлгийхний зүгээс нөгөө бүлгээ тодорхойлдог үзэл бодол, хандлагыг юу гэдэг вэ?**
   А. Бурангуй үзэл Б. Алагчлал
   В. Тэгш бус байдал Г. Давхраажилт
6. **Хувь хүний бүтээлч сэтгэлгээ, ур чадвар, авьяас билгээс эх сурвалжтай, оюуны өмчөөр хамгаалагдсан соёлын агуулга бүхий бараа, бүтээл үйлдвэрлэх, тэдгээрийн хуваарилалт, нийлүүлэлтийн тогтолцоог хангасан үйлдвэрлэлийн салбарыг юу гэж тодорхойлдог вэ?**
   А. Соёлын үйлдвэрлэл Б. Соёлын даяаршил В. Соёлын адилсал Г. Соёлын дархлаа

7. **Соёлын аялал жуулчлалын баримталдаг зарчмуудаас илүүцийг ол.**
   А. Орон нутгийн хүн амын амьжиргаа, нийгэм, эдийн засгийн хөгжилд үр ашгаа өгөх
   Б. Байгалийн болон соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг бэхжүүлэх
   В. Соёлын солилцоонд тулгуурлах
   Г. Олон улсын харилцаа, харилцан хүндэтгэл, ойлголцол, энх тайвнаар зэрэгцэн орших зорилгод эерэгээр нөлөөлнө
8. **Зам харилцаа, эдийн засгийн харилцаа, мэдээлэл харилцааны хөгжлийн үндсэн дээр тусгаар соёлууд дэлхийн нэгдмэл соёлд нэгдэх үйл явцыг юу гэдэг вэ?**
   А. Соёлын үйлдвэрлэл Б. Соёлын даяаршил В. Соёлын адилсал
   Г. Соёлын дархлаа
9. **Соёлын дархлаа сулардаг гол шалтгаан юу вэ?**
   А. Бусдын соёлыг хуулбарлан дуурайх Б. Өөр соёлын зүгээс соёлын тулгалт хийх
   В. Соёлын нэвчих үзэгдэл давамгайлах Г. А ба Б хариулт зөв
10. **Хуурмаг эрх чөлөө нь хүнийг ганцаардуулж, хорвоо ертөнцөд итгэх юмгүй , айж хургасан нэгэн болгодог гэж үзсэн социологич хэн бэ?**
    А. Жон Локк Б. Дж.Кембелл В. Э.Фромм Г. Ф.Тённис
11. **Татвар хураалтын үндсэн зарчмуудыг тодорхойлсон зах зээлийн онолыг үндэслэгч хэн бэ?**
    А. А.Смит Б. А.Маршалл В. Ж.Кейнс Г. Д.Рикардо

12. **Эдгээрээс аль нь Ж.Кейнсийн үзэл санаанд хамаарахгүй вэ?**
    А. Зах зээлийн тогтолцоо нь эдийн засгийн уналтаас өөрийгөө аварч үл чадна.

Б. Төрийн оролцоотойгоор нийт эрэлтийг нэмэгдүүлэх замаар эдийн засагт зохицуулалт хийх нь үр ашигтай.
В. Зах зээлийн харилцаа нь “үл үзэгдэгч гар”-ын онолын дагуу явагдвал илүү үр дүнд хүрнэ.
Г. Нийт эрэлтийг нэмэгдүүлэхдээ төрийн худалдан авалтын зардлыг аль болох чухалд үзэх хэрэгтэй.

13. **Улс орнуудын хооронд бараа, үйлчилгээ шилжих хөдөлгөөнийг ............................ гэнэ.**
А. Гадаад худалдааны тэнцэл Б. Гадаадын шууд хөрөнгө оруулалт
В. Олон улсын худалдаа Г. Гадаад худалдааны бараа эргэлт

14. **Төр татвараас гадна тодорхой төрлийн барааны импорт хязгаарлалт буюу квот тогтоож өгөх тохиолдол байдаг. Жишээ: Тухайн оронд жил орох барааны тоо хэмжээг 20 мянган ширхэгээс хэтрүүлэхгүй байх гэх мэт. Ийм арга хэмжээг гадаад худалдааны ямар бодлого гэж нэрлэдэг вэ?**
А. Капиталын бодлого Б. Демпинг В. Санхүү мөнгөний бодлого
Г. Протекционист бодлого

15. **Дэлхийн улс орнуудын хооронд бүтээгдэхүүн солилцох явцад үүсэж байгаа харилцааг.......................... гэнэ.**
А. Олон улсын зах зээл Б. Дэлхийн зах зээл
В. Дэлхийн худалдаа Г. Дэлхийн интеграци

16. **“Тогтвортой хөгжил”-ийн үзүүлэлтэнд илүүц зүйл байна уу?**
А. Бичиг үсэгт тайлагдсан байдал Б. Эдийн засаг
В. Байгаль орчин Г. Нийгмийн байдал

17. **Үндэстэн дамнасан корпораци аль нь вэ?**
А. Бусад улс орнууудтай тогтоосон худалдааны харилцааг зохицуулах зорилгоос төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нийлбэр цогц
Б. Гадаад орнуудад хоёр болон түүнээс олон үйлдвэрлэл, үйлчилгээний салбартай компани
В. Бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэр байгуулах эсвэл худалдан авах
Г. Үйлвэрлэгчид гадаад орнуудын шинэ зах зээлд нэвтрэхийн тулд өрсөлдөгчөөсөө доогуур үнээр бараагаа шахаж дараа нь үнэ өсгөх зорилготой түр зуурын үзэгдэл

18. **Иргэний нийгэм нь төрөөс үл хамаарах өөр хоорондын харилцаа, эрх зүйгээр зохицуулагддаг хувь хүмүүс, анги бүлэг, институтуудын нийлбэр цогц юм гэж хэн хэлсэн бэ?**
А. И.Кант Б. Г.Гегель В. Р.Дарендорьф Г. Р.Путнам

19. **.................... гэдэг нь хоёр ба түүнээс дээш тооны нэр дэвшигч, улс төрийн нам, эвслээс иргэн хүн тэгш эрхтэйгээр сонголтоо өөрийн биеэр, чөлөөтэй хийж, үр дүн нь шууд гардаг улс төрийн сонголт юм**
А. Төр Б. Нам В. Сонгууль Г. Засаглал

20. **Сонгуулийн чөлөөтэй сонгох зарчимд хамаарах өгөгдөл аль нь вэ?**
А. Нас хүйс, яс үндэс, гарал угсаа, мэргэжил, хэл, санхүүгийн чадвараас үл шалтгаалан бүгд оролцох
Б. Сонгогч бүр ижил тооны санал гаргах эрхтэй бөгөөд санал бүр адил жинтэй байх
В. Сонгогч ямар нэгэн дарамт шахалтгүйгээр гагцхүү өөрийн үзэмжээр саналаа өгөх явдал
Г. Сонгуульд оролцохдоо чөлөөт сонголтоо хийн, саналаа чөлөөтэй илэрхийлэх бүхий л бололцоогоор хангагдах ѐстой.

21. **“ Хорих ял эдэлж байгаа, эрх зүйн чадамжгүй буюу сэтгэцийн өвчтэй гэдэг нь шүүхээр тогтоогдсон тохиолдолд сонгуулийн ямар эрхийг нь хязгаарладаг вэ?**
А. Сонгох эрхийн шалгуур Б. Сонгогдох эрхийн шалгуур
В. Төрийн тусгай албаны шалгуур Г. Төрийн жинхэнэ албаны шалгуур

22. **2008 оны парламентийн сонгуульд Монгол улсын иргэн Амарсүх монгол ардын намаас нэр дэвшин сонгуульд өрсөлдөж, улмаар тойрогтоо өрсөлдөгчөөсөө илүү олон санал авч Монгол улсын Их хурлын гишүүн болсон. Энэ нь сонгуулийн аль тогтолцоонд хамаарах вэ?**
А. Дийлэнх олонхийн Б. Хувь тэнцүүлэх тогтолцоо
В. Холимог тогтолцоо Г. Пропорциональ тогтолцоо

23. **Албан татвар төлөх, төрийн алба, цэргийн алба хаших зэргээр материаллын дэмжлэг үзүүлэх, хууль журмыг дагаж мөрдөх, төрийн албан ѐсны мэдээлэл, бэлгэдлийг хүндэтгэн үзэх зэрэг нь улс төрийн тогтолцооны аль бүрэлдэхүүнд хамаарах вэ?**

А. Бодит дэмжлэг Б. Оролцооны дэмжлэг В. Гадаад шаардлага
Г. Дотоод шаардлага

**24. Улс төрийн тогтолцоог бүтэц-чиг үүргийн талаас нь авч үзвэл сонирхлыг илэрхийлэх, нэгтгэх, хэрэгжүүдэх үйл ажиллагаа хэмээн тодорхойлдог. Тэгвэл сонирхлын хэрэгжилтийг хангадаг байгууллага аль нь вэ?**

А. Улс төрийн намууд Б. Сонирхлын бүлгүүд В. Шахалтын бүлгүүд Г. Төр

**25. Ж.С.Миллийн хэлсэн үг аль нь вэ?**

А. Төр бол “ левиафан”
Б. Аливаа эрх мэдэл хүнийг эвддэг бол хязгааргүй эрх мэдэл хязааргүй эвддэг
В. Эрх мэдэл ба зах зээл
Г. Төр бол “ зайлшгүй байх ёстой муу зүйл”

**26. Зөвхөн Үндсэн хууль зөрчсөн талаар маргааныг шийдвэрлэж, засаг хуульд заасан тодорхой байгууллага, албан тушаалтны шийдвэр үйл ажиллагаа үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьдаг байгууллага юу вэ?**

А. Улсын ерөнхий прокурор Б. Үндсэн хуулийн цэц В. Улсын дээд шүүх
Г. Улсын их хурал

**27. Иргэний хэргийн шүүхэд хандаж эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус баялагтай холбоотой маргаж байгаа буюу зөрчигдсөн эрх, ашиг сонирхлоо хамгаалахын тулд анхан шатны шүүхээр дамжуулан эрх зөрчигчид тавьж буй шаардлагыг юу гэдэг вэ?**

А. Мэдэгдэл Б. Өргөдөл В. Гомдол Г. Нэхэмжлэл

**28. Манай улс хэдэн оноос “ Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай” хууль батлагдсан бэ?**

А. 2010 он Б. 2013 он В. 2016он Г. 2018 он

**29. Иргэн хуулийн этгээдээс захиргааны байгууллагад гомдол гаргах хугацааг хэд хоногийн дотор байхаар тогтоож өгсөн байдаг вэ?**

А. 14 хоног Б. 30 хоног В. 45 хоног Г. 60 хоног

**30. Тухайн эрхийг эдлэхэд ямарваа нэгэн саад учруулахгүй, зөрчихгүй байхыг ойлгодог. Төрийн зүгээс хүмүүсийн эрхээ эдлэх гэсэн үйлдлийг хязгаарлах, хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулж болохгүй гэсэн нь хүний эрхийн талаар төрийн аль үүрэг вэ?**

А. Хүндэтгэх Б. Хангах
В. Хамгаалах Г. Ахиц дэвшилт гаргах

**31. Дорнод аймгийн шүүх нь .............................. шүүх юм.**

А. Сум, сум дундын шүүх Б. Аймаг, нийслэлийн шүүх
В. Улсын дээд шүүх Г. Хяналтын шатны шүүх

**32. Хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэгч, механизмыг тогтоосон олон улсын хүний эрхийн 4 баримт бичгийг.................... гэнэ.**

А. Хүний эрхийн тунхаглал Б. Хүний эрхийн нэмэлт протокол
В. Хүний эрхий билл Г. Олон улсын хүний эрхийн билл

**33. Засгийн газрын оролцоо дэмжлэггүйгээр улс үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулдаг глобал түвшний оролцогчид, тоглогчид олон улсын байгууллагыг хамруулан үздэг ойлголтыг юу гэдэг вэ?**

А. Олон улсын харилцаанд оролцогч Б. Улс бус оролцогч
В. Зөөлөн хүчний бодлого Г. Хатуу хүчний бодлого

**34. ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол улсын гадаад харилцааны бодлогын........................... мөн.**

А. Хоёр дахь зорилт Б. Эн тэргүүний зорилт В. Гурав дахь зорилт
Г. Дөрөв дэх зорилт

**35. Нутгийн өөрөө удирдах байгууллагыг харуулсан бүдүүвчийг ажиглаад алдаатай хэсгийн дугаарыг сонгоно уу.**

| | |
|---|---|
| 1. Иргэдийн төлөөлөгчдийн хурал | •Аймаг, нийслэлийн засаг дарга |
| 2. Сум, дүүргийн засаг дарга | •Орон нутгийн агентлаг |
| 3. Иргэдийн нийтийн хурал | •Баг, хорооны засаг дарга |

**А. 3, 1** **Б.3** **В. 1** **Г. 2**

**36. Монгол Монгол улстай түншлэлийн харилцаатай улсуудыг харуулсан бүдүүвчийг гүйцээгээрэй.**




**А. а-Стратегийн түншлэл, b-Энэтхэг** **Б. а-Иж бүрэн стратегийн түншлэл, b-БНХАУ**
**В. а-Стратегийн түншлэл, b-БНСУ** **Г. а-Иж бүрэн түншлэл, b-АНУ**

**37. ДНБ-ий үзүүлэлтийг тодорхойлолттой нь харгалзуулна уу.**

| | | | |
|---|---|---|---|
| a | Бодит ДНБ | 1 | Дотоод болон хилийн чанад дахь Монголын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжүүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг |
| b | Нэрлэсэн ДНБ | 2 | Тухайн жилийн бараа бүтээгдэхүүнийг өнөөгийн үнээр тооцохыг хэлнэ |
| c | Үндэсний нийт бүтээгдэхүүн | 3 | Тухайн жилийн бараа бүтээгдэхүүнийг тогтмол үнээр тооцох үзүүлэлт |
| d | Дотоодын нийт бүтээгдэхүүн | 4 | Тухайн оны ДНБ-ийг өмнөх оны ДНБ-д харьцуулаад 100 хувьд үржүүлж тооцоолно. |
| e | ДНБ-ийн өсөлтийг тооцох | 5 | Тухайн улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн, эцсийн бараа, үйлчилгээний зах зээлийн үнийн дүн |

А. A3,B2,C1,D5,E4 Б. A5,B3,C1,D4,E2 В. A5,B4,C3,D2,E1 Г. A2,B1,C5,D4,E3

**38. Д. Истоны улс төрийн системийн ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу.**

| | | | |
|---|---|---|---|
| a | Шаардлага | 1 | Аль нэг нам, нэр дэвшигчийн төлөө санал өгөх, шийдвэрийг дэмжиж буйгаа илэрхийлэх |
| b | Оролцооны дэмжлэг | 2 | Улс төрийн системийн дотроос эсвэл, түүнийг хүрээлэн байгаа экологи, эдийн засаг, соёл зэрэг янз бүрийн системүүдээс гарч буй тулгалтууд |
| c | Бодит дэмжлэг | 3 | Нийгмийн хурцадмал, тогтворгүй байдлыг арилгах гол механизмын үүргийг гүйцэтгэдэг онцлогтой |
| d | Шийдвэр | 4 | Төрийн бодлогын тодорхой илрэл болсон төрийн хууль тогтоомж, мэдээлэл, сурталчилгаа гэх мэт |
| e | Эргэх холбоо | 5 | Татвар төлөх, төрийн болон цэргийн алба хаших, хууль дүрмийг дагаж мөрдөх |

А. A3,B2,C1,D5,E4 Б. A5,B3,C1,D4,E2 В. A5,B4,C3,D2,E1 Г. A2,B1,C5,D4,E3

**39. Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх хугацааг харгалзуулна уу.**

| | | | |
|---|---|---|---|
| a | Гомдол хүлээн авсан шүүх хэрэгт улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, хэргийн оролцогчдын гомдлыг хавсарган гомдлыг хүлээж авсан өдрөөс хойш нийслэлд .......... дотор улсын дээд шүүхэд хүргүүлнэ. | 1 | 30 хоног |
| b | Шүүгч нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш ....... дотор хэрэг үүсгэх тухай захирамж гаргана. | 2 | 90 хоног |
| c | Хэрэг үүссэн өдрөөс хойш орон нутагт ........ дотор шүүх | 3 | 14 хоног |

| | | | |
|---|---|---|---|
| | нэхэмжлэлийг хариуцагчид гардуулна. | | |
| d | Давж заалдах гомдол гаргасан хэргийг, давж заалдах шүүх хүлээн авснаас хойш ......... дотор хянан шийдвэрлэнэ. | 4 | 3 хоног |
| e | Зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хугацаа хэтэрсэн тохиолдолд гомдол хүлээн авсан захиргааны байгууллага, албан тушаалтан хугацаа хэтэрснээс хойш ...... дотор нөхөн сэргээнэ. | 5 | 7 хоног |

А. A3,B2,C1,D5,E4 Б. A5,B3,C1,D4,E2 В. A5,B4,C3,D2,E1 Г. A4,B5,C3,D1,E2

**40. Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллага, бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудыг харгалзуулна уу.**

| | | | |
|---|---|---|---|
| a | UNDP | 1 | НҮБ-ын “Хөгжлийн хөтөлбөр” |
| b | UNESCO | 2 | Ази номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга |
| c | АСЕАН | 3 | НҮБ-ын “Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага” |
| d | АПЕК | 4 | Зүүн өмнөд Азийн орнуудын холбоо |
| e | АСЕМ | 5 | Ази-Европын уулзалт |

А. A3,B2,C1,D5,E4 Б. A1,B3,C4,D2,E5 В. A5,B4,C3,D2,E1 Г. A2,B1,C5,D4,E3

**НИЙГМИЙН УХААНЫ 11-Р АНГИЙН ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

**ХУГАЦАА: 80 МИНУТ**

**НИЙТ ОНОО: 40**

**В хувилбар**

1. **Америк судлаач Ө. Күүс 1990-ээд онд нийгэм, эдийн засийн ялгаа бүхий гурван ангийг хүмүүс өөрсдийн өнгө шинж тэмдгийг хэрхэн тайлбарладаг болохыг судалсан. Доорх өгөгдлөөс хамааралгүй ангийг олно уу?**
   А Эдийн засгийн хувьд хамгийн амжилттай яваа анги
   Б. Цалингаараа амьдардаг дундаж хэсгийхэн
   В. Бага орлоготой ажилчин анги
   Г. Ур чадвараар бага даржин амьдралтай хэсгийнхэн
2. **Ядуу хүмүүс бодит хэрэгцээнээсээ бага эрүүл мэндийн үйлчилгээ авч байгаа нь нэгдүгээрт санхүүгийн боломж, хоёрдугаарт ядуусын соёл, гуравдугаарт нийгмийн институтийн саад бэрхшээлтэй холбоотой үзсэн социологич хэн бэ?**
   А. Ө. Күүс Б. Д.Датон В. Л.Козер Г. Е.О. Райт
3. **Эдийн засгийн баялаг, нэр хүнд, эрх мэдэлд хүрэх адил бус боломж бүхий байдлыг юу гэх вэ?**
   А. Нийгмийн ялгарал Б. Тэгш бус байдал В. Нийгмийн давхраажилт
   Г. Нийгмийн давхраа
4. **Гол төлөв Азийн орнуудын давхраажилтад илэрдэг, шашны номлолоор зөвтгөгдөн, хөдөлмөрийн хуваарьтай нь холбогдон тодорхойлогдсон, хувийн байр суурийг өөрчлөх ямар ч боломжгүй уламжлалт хаалттай давхраажилтын тогтолцоо аль нь вэ?**
   А. Боолчлол Б. Каст В. Язгуур угсаа Г. Анги – бүлэг
5. **Давхраажилтын дараах хэмжигдэхүүнээс эрх мэдлийн төрөлд аль нь хамаарах вэ?**
   А. Үл хөдлөх хөрөнгө эзэмших Б. Бусдад нөлөөлөх, дагуулах
   В. Хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт, үнэ цэн Г. Онцгой авьяас чадвар
6. **Үндэсний соёлын өвөрмөц өв санг дэлхий нийтэд үзүүлэн таниулах хэрэгцээ улам нэмэгдэж байгаа өнөө үеийн соёлын солилцооны гол хөтлөх хүч нь дотоодын болон олон улсын.......................................... мөн.**
   А. Соёлын аялал жуулчлал Б. Соёлын үйлдвэрлэл В. Соёлын даяаршил
   Г. Соёлын дархлаа
7. **Тухайн цаг үеийн хүчирхэг гүрнүүдийн зүгээс бага буурай улс оронд хандсан үйлдэл бөгөөд бүтээсэн бүхнийг устгаж, хүнийг тэр зүйлээ дахин бүтээхгүй болтол нь айлган сүрдүүлэх үйл явц нь соёлын харилцан үйлчлэлийн ямар хэлбэр вэ?**
   А. Соёлын давамгайлал Б. Соёлын соёлын солилцоо
   В. Соёлыг хуулбарлан дуурайх Г. Соёлын тулгалт
8. **Манай судлаачид юуг “соёлын ижилсэл”,” соёлын өөрийншил”,” соёлын өвөр төрх” гэх зэргээр нэрлэх нь бий вэ?**
   А.Соёлын орон зай Б. Соёлын даяаршил В. Соёлын адилсал
   Г. Соёлын дархлаа
9. **Хүнд төрөлхөөс заясан гурван эрх байна. Энэ нь амьдрах эрх, эрх чөлөөтэй байх, өмчлөх эрхтэй гэж заасан социологич хэн бэ?**
   А. Жон Локк Б. Дж.Кембелл В. Э.Фромм Г. Ф.Тённис
10. **Харийн соёлд дасан зохицох хэдэн үе шат байдаг вэ?**
    А. 5 Б. 6 В. 7 Г. 8
11. **Хуулийн дагуу,тогтоогдсон хэмжээгээр бүх хүн, хуулийн этгээдээс төрд заавал төлөх, буцалтгүй шинжтэй хураамжыг юу гэдэг вэ?**
    А. Татвар Б. Хураамж В. Төлбөр Г. Шимтгэл
12. **Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх бодлогыг юу гэдэг вэ?**

А. Улсын төсөв Б. Төсвийн бодлого
В. Сангийн бодлого Г. Төрийн мөнгө, зээлийн бодлого

13. **Валютын интервенци хэмээх ойлголтыг илэрхийлсэн тодорхойлолтыг доорх өгөгдлүүдээс сонгоно уу.**
А. Гадаадын нэгж валютыг өөрийн валютаар худалдан авах үнэ
Б. Төв бакнаас валютын ханшийг өсгөх үйл ажиллагаа
В. Төв бакнаас валютын ханшийг бууруулах үйл ажиллагаа
Г. Төв банк өөрийн нөөцөөр валютыг худалдан авах үйл ажиллагаа

14. **Демпингийн үйл ажиллагаа гэж юу вэ?**
А. Импортын бараанд үнэ тарифийн хязгаарлалт хийх үйл ажиллагаа
Б. Импортын барааны тоо хэмжээнд нь хязгаар тогтоох үйл ажиллагаа
В. Импортлож байгаа бараанд татвар ноогдуулах үйл ажиллагаа
Г. Бараа, үйлчилгээг гадаад зах зээлд нэвтрүүлэхийн тулд өрсөлдөгчөөсөө доогуур үнээр худалдаалах үйл ажиллагаа

15. **Гадаадын шууд хөрөнгө оруулалт аль нь вэ?**
А. Гадаад орнуудад хоёр болон түүнээс олон үйлдвэрлэл, үйлчилгээний салбартай компани
Б. Бусад улс орнуудтай тогтоосон худалдааны харилцааг зохицуулах зорилгоос төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нийлбэр цогц
В. Бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэр байгуулах эсвэл худалдан авах
Г. Тухайн орны үнэт цаасыг гадаадын худалдан авагчдад худалдана

16. **Нэг хүнд ногдох Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт нь.............харуулдаг.**
А. Тухайн улсын эдийн засгийн чадавхийг харуулдаг
Б. Тухайн улсын иргэдийн амьдралын түвшинг харуулдаг
В. Тухайн улсын экспортын нийт хэмжээг харуулдаг
Г. Тухайн улсын экспорт, импортын зөрүүг харуулдаг

17. **НҮБ-аас хүний хөгжлийн индексийг дараах гурван үзүүлэлтээр тодорхойлдог. Гүйцээж бичнэ үү**
1. Хүн амын дундаж наслалт 2. Нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ 3.................
А. Нийгмийн байдал Б. Хүн амын орлогын түвшин В. Эдийн засаг
Г. Боловсролын түвшин

18. **“Аливаа зүйлийг хийж бүтээнэ гэдэг нь өчүүхэн ч атугай бусадтай чөлөөтэй хамтран ажиллана гэсэн үг. Энэ нь чөлөөт эвсэл холбоо болон байгууллагуудын сүлжилсэн ертөнц болж дараа нь бие даасан институтууд бий болоход хүргэдэг” гэж хэн хэлсэн бэ?**
А. И.Кант Б. Г.Гегель В. Р.Дарендорьф Г. Р.Путнам

19. **Сонгогдох эрхийн шалгуурт хамааралгүй зүйл аль нь вэ?**
А. Гадаадад дээд боловсрол эзэмшсэн байх
Б. Сүүлийн 5 жил эх орондоо тогтвор суурьшилтай амьдарсан
В. УИХ-ын гишүүнд нэр дэвшихэд 25 нас хүрсэн байх
Г. Ерөнхийлөгчид нэр дэвшихэд 45 нас хүрсэн байх

20. **Ардчилсан сонгуулийн зарчимд хамаарахгүй өгөгдөл аль нь вэ?**
А. Бүх нийтээр оролцох зарчим Б. Заавал саналаа өгөх зарчим
В. Тэгш оролцох зарчим Г. Саналыг шууд өгөх зарчим

21. **Энэ нь намуудаас нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаар санал хураах тогтолцоо бөгөөд сонгогч хүнд нь бус намд нь саналаа өгдөг. Энэ нь сонгуулийн аль тогтолцоо вэ?**
А. Мажоритар тогтолцоо Б. Пропорциональ тогтолцоо
В. Параллель тогтолцоо Г. Энгийн олонхийн тогтолцоо

22. **Нам дотроо нэрийн жагсаалтаар парламентын гишүүдийг бүрдүүлдэг.Нам, эсвэл суудал авахын тулд тогтоосон босго давах ёстой гэсэн ямар тогтолцооны талаар мэдээлж байна вэ?**

А. Холимог тогтолцоо Б. Хувь тэнцүүлэх тогтолцоо
В. Харьцангуй олонхийн саналаар сонгох Г. Энгийн олонхийн саналаар сонгох

23. **Нийтлэл, нэвтрүүлгийн тусламжтайгаар үнэн бодитой мэдээллээр шуурхай, тогтмол хангах зорилго бүхий тогтмол хэвлэл, радио, телевиз, мэдээллийн агентлаг, баримтат кино, цахим хэвлэл зэргийг .................................... гэдэг.**
А. Мэдээлэл холбоо Б. Хэвлэл мэдээлэл
В. Холбоо мэдээлэл Г. Мэдээлэл

24. **Улс төрийн системийн гадаад шаардлага аль нь вэ?**
А. Ерөнхий сайдыг огцруулах Б. Цалин тэтгэврийг нэмэх
В. Сонгуулийн хуулийг өөрчлөх Г. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах

25. **................. нь засаглалын эрх мэдлийг хуваарилах, хүний эрхийг баталгаажуулах, улс орны суурь гол харицааг зохицуулах үүрэгтэй дээд хүчин чадалтай засаг, төрийн гол хууль юм.**
А. Хууль Б. Үндсэн хууль В. Засаглах хууль Г. Хууль, тогтоомж

26. **Үндсэн хуулийн хамгаалагч гэж хэнийг хэлэх вэ?**
А. Улсын ерөнхий прокурор Б. Үндсэн хуулийн цэц
В. Улсын дээд шүүх Г. Улсын ерөнхий шүүгч

27. **“Эрх мэдэл ба зах зээл” хэний бүтээл вэ?**
А. Мюррей Н.Ротбард Б. Ф.Бастиа В. Р.Нозик Г. Ж.С.Милль

28. **Монгол улсын 2015 онд батлагдсан шинэ Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт өмчлөх эрхийн эсрэг чиглэсэн 12 төрлийн нийгэмд аюултай үйлдлийг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн ял, шийтгэл оногдуулахаар тусгажээ. Илүүцийг ол**
А. Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших
Б. Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх
В. Нотариатч, улсын бүртгэгч өмчлөгчийн эрхийг зөрчих
Г. Бусдыг хэл амаар гутаан доромжлох, шоолох

29. **Захиргааны хэргийн оролцогчид анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл хэд хоногийн дотор захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хандан гомдол гаргах эрхтэй гэж үздэг вэ?**
А. 14 хоног Б. 30 хоног В. 45 хоног Г. 60 хоног

30. **Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нь сэргээх, хохирлыг арилгах бүтэц, тогтолцоог бий болгох боловсронгуй хууль тогтоомж батлахыг ойлгодог гэсэн нь хүний эрхийн талаар төрийн аль үүрэг вэ?**
А. Хүндэтгэх Б. Хангах
В. Хамгаалах Г. Ахиц дэвшилг гаргах

31. **Олон улсын гэрээний хэлбэрүүдээс илүүцийг ол.**
А. Тунхаглал Б. Конвенц, пакт
В. Протокол Г. НҮБ-ын албан ёс шинэчилсэн найруулга

32. **Шударга ёс гэдэг бол “ хүн бүрд зохих хувийг нь өгөх” хэн тодорхойлсон бэ?**
А. Ромын эзэн хаан Юстинан Б. Вавилоны хаан Сирүс
В. Чингис хаан Г. Пальмерстон

33. **“Транспаренси Интернэшл” байгууллага олон улсын харилцаанд ямар шинжтэйгээр оролцдог вэ?**
А. Улс дэх оролцогч Б. Улс бус оролцогч В. ОУ-ын хүмүүнлэнгийн чиглэлээр Г. Олон улсын төрийн бус байгууллага

34. **1991 онд Персийн булангийн үйл явцын талаар CNN дайны талбараас шуурхай мэдээ хүргэснээр дэлхийн улс орнуудад бодит мэдээллийг газар дээрээс нь шууд хүргэх эхлэл болсон гэх мэдээлэл улс бус оролцогчдын ямар ангилал нь вэ?**
А. Шашны бүлэг Б. ОУ-ын хэвлэл мэдээллийн хэрэгсэл
В. Үндэстэн дамнасан корпорац Г. ТББ

35. **Дараах бүдүүвчийг ажиглаад соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд баримтлах зарчмуудыг гүйцээгээрэй.**




А. Тухайн соёлын бусдаас ялгарах, дахин давтагдашгүй өвөрмөц шинжийг нээх

Б. Эрх чөлөө, ардчилал, хүлээцтэй байдал, шударга ёсны үнэ цэнийг дэлгэрүүлэх

В. Дэлхийд өөрсдийн брэндийг бий болгож, шударга өрсөлдөөнийг дэмжих
Г. Байгалийн болон соёлын өвийн газруудтай харилцан шүтэлцээтэй хөгжүүлэх

**36. Дараах бүдүүвчийг ажиглаад соёлын харилцан үйлчлэлийн хэлбэрийг гүйцээгээрэй.**




А. Соёлыг тулгалт Б. Соёлын цочирдол В. Соёлын
солилцоо
Г. Соёлын эрх чөлөө

**37. ДНБ-ний үзүүлэлтийг тодорхойлолттой нь харгалзуулна уу.**

| | | | |
|---|---|---|---|
| a | Бодит ДНБ | 1 | Тухайн улсын хэмжээнд жилийн турш үйлдвэрлэсэн баялгийн орлогын нийлбэр дүн |
| b | Нэг хүнд ногдох ДНБийн өсөлт | 2 | Хэрэглэгчдийн эцсийн хэрэглээндээ зориулан худалдан авахад зарцуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлбэр |
| c | Бодит ДНБ-ийн өсөлт | 3 | Тухайн улсын улсын эдийн засгийн чадавхыг харуулдаг. |
| d | ДНБ-ийг зардлаар тооцох | 4 | Тухайн улсын иргэдийн амжиргааны түвшинг илтгэнэ. |
| e | ДНБ-ийг орлогоор тооцох | 5 | Тухайн жилийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн түвшний ерөнхий өсөлт буюу инфляцийн түвшинд харьцуулж тодорхойлно. |

А. A3,B2,C1,D5,E4 Б. A1,B3,C4,D2,E5 В. A5,B4,C3,D2,E1 Г. A2,B1,C5,D4,E3

**38. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу.**

| | | | |
|---|---|---|---|
| a | Оролтод хамаарах шаардлага | 1 | Төрийн бодлогын тодорхой илрэл болсон төрийн хууль тогтоомж, мэдээлэл, сурталчилгаа гэх мэт |
| b | Оролцооны дэмжлэг | 2 | Төрийн албан ёсны мэдээлэл, бэлгэдлийг хүндэтгэх |
| c | Бодит дэмжлэг | 3 | Тодорхой бодлого, шийдвэрийг дэмжиж буйгаа илэрхийлэх |
| d | Үйлдэл | 4 | Улс төрийн системийн дотроос эсвэл, түүнийг хүрээлэн байгаа экологи, эдийн засаг, соёл зэрэг янз бүрийн системүүдээс гарч буй тулгалтууд |
| e | Эргэх холбоо | 5 | Улс төрийн системд хувьсан өөрчлөгдөж буй орчинд зохицох, шинэчлэх, өөрийгөө хадгалах бололцоог олгодо |

А. A4,B3,C2,D1,E5 Б. A1,B3,C4,D2,E5 В. A5,B4,C3,D2,E1 Г. A2,B1,C5,D4,E3

**39. Бүрэн тэтгэвэр тогтоолгох үндэс болон нийгмийн даатгалын сангаас олгодог тэтгэмжүүдийг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /5 оноо/**

| | | | |
|---|---|---|---|
| a | Бүрэн тэтгэвэр тогтоолгох үндэслэл | 1 | Нийгмийн даатгалын шимтгэлийг 3 болон түүнээс дээш сарын хугацаагаар төлсөн байх |
| b | Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох нөхцөл | 2 | Нийгмийн даатгалын шимтгэлийг 20-оос доошгүй жил төлсөн 60 насанд хүрсэн эрэгтэй, 55 насанд хүрсэн эмэгтэй |
| c | Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж олгох нөхцөл | 3 | Нийгмийн даатгалын шимтгэлийг 36 сараас доошгүй хугацаагаар төлсөн байх |
| d | Оршуулгын тэтгэмж олгох нөхцөл | 4 | Нийгмийн даатгалын шимтгэлийг 12 сар төлсөн, сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн байх |
| e | Ажилгүйдлийн тэтгэмж олгох нөхцөл | 5 | Нийгмийн даатгалын шимтгэлийг 24 сараас доошгүй хугацаанд төлсөн, сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн байх |

А. A2,B1,C4,D3,E5 Б. A1,B3,C4,D2,E5 В. A5,B4,C3,D2,E1 Г. A2,B1,C5,D4,E3

**40. Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллага, бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудыг харгалзуулна уу.**

| | | | |
|---|---|---|---|
| a | UNESCO | 1 | 1957 онд Ромын гэрээгээр байгуллагадсан |
| b | ШХАБ | 2 | Шанхайн хамтын ажиллагааны байгууллага |
| c | Европын холбоо | 3 | НҮБ-ын “Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага” |
| d | ACEM | 4 | Нэгдсэн үндэсний байгууллагын “Хүүхдийн сан” |
| e | UNICEF | 5 | Ази-Европын уулзалт |

А. A4,B2,C1,D5,E4 Б. A3,B2,C1,D5,E4 В. A5,B4,C3,D2,E1 Г. A2,B1,C5,D4,E3

**НИЙГМИЙН УХААНЫ 11-Р АНГИЙН ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

**ХУГАЦАА: 80 МИНУТ**

**НИЙТ ОНОО: 40**

**С хувилбар**

1. **Америкийн судлаач Ө.Күүс 1990-ээд онд нийгэм, эдийн засгийн ялгаа бүхий гурван ангийн хүмүүс өөрсдийн өвчний шинж тэмдгийг хэрхэн тайлбарладаг болохыг судалжээ. Тэрээр нэг дэх ангид эдийн засаг, санхүүгийн хувьд хамгийн амжилттай байгаа, хоёр дахь ангид цалингаараа амьдардаг дундаж хэсгийнхнийг,гурав дахь ангид ур чадвар бага, даржин амьдралтай хэсгийхнийг багтаасан. Нэг дэх ангийн хүмүүсийн хандлага аль нь вэ?**
   А. Өвчний нэг шинж тэмдэг илрэхэд эмчид хандаж эрүүл мэндийн үйлчилгээ авахаар эрэлхийлдэг
   Б. 17 шинж тэмдгийн 10 шинж тэмдгийг эмнэлэгт үзүүлэх ноцтой шинж биш гэж үздэг
   В. Өвчний шинж илрээгүй байсан ч эмнэлэгийн хяналтанд тогтмол байдаг
   Г. Санхүүгийн хувьд санаа зоволтгүй тул өвчин эмгэг тусдаггүй
2. **Үйлдвэрт ямар машин техник авах вэ гэдгийг шийдэхэд жирийн ажилчин хүн оролцох боломжоор хомс бол инженер техникийн ажилтан, менежрүүдийн  хувьд саналаа илэрхийлэх, цаашлаад шийдвэр гаргахад шууд оролцож байдаг. Энэ нь байр суурийн ямар өгөгдлийг өөртөө илүү агуулж байна вэ?**
   А. Хэр зэрэг эрх мэдэлтэй вэ гэдгээс хамааран
   Б. Ямар байр суурь эзэлж байгаагаасаа хамаарч
   В. Ямар баялаг эзэмшиж байгаагаас хамаарч
   Г. Алдар хүнд, хүндэтгэлийн зэргээс хамаарч
3. **Тодорхой хэв шинжит харилцаа бүхий тэгш бус байдлын тогтолцоог юу гэдэг вэ?**
   А. Нийгмийн ялгарал　Б. Тэгш бус байдал　В. Нийгмийн давхраажилт
   Г. Нийгмийн давхраа
4. **К.Марксын үйлдвэрлэлийн хэрэгсэлтэй харилцах харилцаа (өмч) –ны ялгарлыг чухалчилсан үзэл санааг үйлдвэрлэлийн харилцаан дахь М.Веберын “хянах” эрх мэдлийн үзэл санаагаар баяжуулсан судлаач аль нь вэ?**
   А. Ө. Күүс　Б. Д.Датон　В. Л.Козер
   Г. Е.О. Райт
5. **Дайн байлдаан, өр төлөөс эсвэл төрийн үзэл суртлын үр дүнд үүсдэг, нэг нь нөгөөгийнхөө өмч нь болж байдаг, албадлагын хөдөлмөрийн харилцаанд тулгуурласан, байр сууриа өөрчлөх боломжоор хомс хаалттай тогтолцоо, давхраажилтын хэв маяг аль нь вэ?**
   А. Боолчлол　Б. Каст　В. Язгуур угсаа　Г. Анги-бүлэг
6. **Соёлын үйлдвэрлэл хэмээх ойлголт анх хэдэн онд гарч ирсэн бэ?**
   А. 1950-аад он　Б. 1960-аад он　В. 1970-аад он
   Г. 1980-аад он
7. **Соёлын аялал жуулчлалын баримталдаг зарчмуудаас илүүцийг ол.**
   А. Орон нутгийн хүн амын амьжиргаа, нийгэм, эдийн засгийн хөгжилд үр ашгаа өгөх
   Б. Байгалийн болон соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг бэхжүүлэх
   В. Соёлын солилцоонд тулгуурлах
   Г. Олон улсын харилцаа, харилцан хүндэтгэл, ойлголцол, энх тайвнаар зэрэгцэн орших зорилгод эерэгээр нөлөөлнө
8. **Бүх шатны сургуульд англи хэлийг зааж байна. Англи, хятад, орос япон, солонгос хэлний сургалтын төв, сургуулиуд олширч байна. Бизнесийн байгууллагуудын ажлын байрны тодорхойлолтыг үзэхэд гадаад хэлний боловсрол хамгийн чухалд тооцогдож байна гэх мэт нь ямар ойлголтыг илэрхийлж байна.**
   А. Соёлын үйлдвэрлэл　Б. Соёлын даяаршил
   В. Соёлын адилсал　Г. Соёлын дархлаа
9. **Манай судлаачид юуг “соёлын ижилсэл”,” соёлын өөрийншил”,” соёлын өвөр төрх” гэх зэргээр нэрлэх нь бий вэ?**

А.Соёлын орон зай Б. Соёлын даяаршил
В. Соёлын адилсал Г. Соёлын дархлаа

10. **Соёлын дархлаа сулардаг гол шалтгаан юу вэ?**
А. Бусдын соёлыг хуулбарлан дуурайх
Б. Өөр соёлын зүгээс соёлын тулгалт хийх
В. Соёлын нэвчих үзэгдэл давамгайлах
Г. А ба Б хариулт зөв

11. **Төсвийн хомсдолыг юу гэдэг вэ?**
А. Интервенц Б. Демпинг В. Дефицит Г. Профицит

12. **Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх бодлогыг төрийн сангийн буюу .......гэж нэрлэдэг.**
А. Улсын төсөв Б. Төсвийн бодлого
В. Сангийн бодлого Г. Төрийн мөнгө, зээлийн бодлого

13. **Мөнгөний бодлогын үндсэн арга хэмжээнүүдийг ....................... бүрэн эрхийнхээ хүрээнд дангаар, бие даан хэрэгжүүлдэг бол төсвийн орлого, зарлагын аливаа нэгэн өөрчлөлтийг ..................... дээр хэлэлцэж байж шийдвэр гаргадаг учраас мөнгөний бодлого нь сангийн бодлогыг бодвол илүү уян хатан чанартай байна.**
А. Монгол банк, УИХ Б. Төв банк, Засгийн газар
В. Төв банк, УИХ Г. Банк, УИХ

14. **Гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ болон үнийн түвшний хооронд шууд холбоо байхгүй бөгөөд төрийн идэвхтэй оролцоо нь эдийн засагт хор учруулна гэж хэн үзсэн бэ?**
А. Ж.Локк Б. Э. Фромм В. Хайек Г. Н.Ротбард

15. **Валютын интервенци хэмээх ойлголтыг илэрхийлсэн тодорхойлолтыг доорх өгөгдлүүдээс сонгоно уу.**
А. Гадаадын нэгж валютыг өөрийн валютаар худалдан авах үнэ
Б. Төв бакнаас валютын ханшийг өсгөх үйл ажиллагаа
В. Төв бакнаас валютын ханшийг бууруулах үйл ажиллагаа
Г. Төв банк өөрийн нөөцөөр валютыг худалдан авах үйл ажиллагаа

16. **Гадаад худалдааны бодлого гэдэг ойлголтыг аль өгөгдөл нь зөв илэрхийлж байна вэ?**
А. Улс орнуудтай тогтоосон худалдааны харилцааг зохицуулах зорилгоор төрөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нийлбэр цогц үйл ажиллагаа
Б. Бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэрлэлээ байгуулах эсвэл худалдан авах үйл ажиллагаа
В. Гадаад орнуудад хоёр болон түүнээс олон үйлдвэрлэл, үйлчилгээний салбартай томоохон компаниудын үйл ажиллагаа
Г. Аль болох олон улс оронтой харилцан ашигтай байдлаар гадаад худалдаа, харилцаагаа өргөжүүлэн явуулах үйл ажиллагаа

17. **Портфелийн хөрөнгө оруулалт аль нь вэ?**
А. Компани бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэр байгуулах, эсвэл худалдан авна
Б. Тухайн орны үнэт цаасыг гадаадын худалдан авагчдад худалдана
В. Үйлвэрлэгчид гадаад орнуудын шинэ зах зээлд нэвтрэхийн тулд өрсөлдөгчөөсөө доогуур үнээр бараагаа шахаж дараа нь үнэ өсгөх зорилготой түр зуурын үзэгдэл
Г. Хилийн чанадад тухайн орны үндэсний валютын нийлүүлэлтийг бий болгоно.

18. **“ Төр, эдийн засаг, гэр бүлээс ангид орших нийгмийн хүрээг иргэний нийгэм гэнэ” хэн хэлсэн бэ?**
А. И.Кант Б. Г.Гегель В. Р.Дарендорьф Г. Р.Путнам

19. **XVII зуунаас баруун Европт төрийн эрх мэдэл гагцхүү ард түмнээс, тэдний итгэл, зөвшөөрлөөс үүсэлтэй гэсэн үзэл баримтлал давамгайлах болсон. Францын болон Америкийн хувьсгалаар иргэн бүр тэгш эрхтэй хэмээн тунхаглаж, энэ үеэс л хууль тогтоох байгууллагад нийгмийн янз бүрийн төлөөллийг сонгох болжээ. Уг мэдээлэл юуны талаар илүү онцолсон бэ?**
А. Төр Б. Нам В. Сонгууль Г. Засаглал

**20. Саналаа нууцаар гаргах зарчим аль нь вэ?**

А. Нас хүйс, яс үндэс, гарал угсаа, мэргэжил, хэл, санхүүгийн чадвараас үл шалтгаалан бүгд оролцох

Б. Сонгогч бүр ижил тооны санал гаргах эрхтэй бөгөөд санал бүр адил жинтэй байх

В. Сонгогч ямар нэгэн дарамт шахалтгүйгээр гагцхүү өөрийн үзэмжээр саналаа өгөх явдал

Г. Сонгуулийн эцсийн үр дүн нь зөвхөн иргэдийн санал хураалтын үр дүнгээр шийдэгддэг.

**21. 1992 оны Үндсэн хуулийн 3-р бүлэг 21-р зүйлд "Улсын их хурлын гишүүнээр МУ-ын 25 нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно" гэж байдаг. Энэ нь улс төрийн сонгуулийн эрхийн аль шалгуур вэ?**

А. Сонгох эрхийн шалгуур　　Б. Сонгогдох эрхийн шалгуур

В. Төрийн тусгай албаны шалгуур　　Г. Төрийн жинхэнэ албаны шалгуур

**22. 2008 оны парламентийн сонгуульд Монгол улсын иргэн Амарсүх монгол ардын намаас нэр дэвшин сонгуульд өрсөлдөж, улмаар тойрогтоо өрсөлдөгчөөсөө илүү олон санал авч Монгол улсын Их хурлын гишүүн болсон. Энэ нь сонгуулийн аль тогтолцоонд хамаарах вэ?**

А. Дийлэнх олонхийн　　Б. Хувь тэнцүүлэх тогтолцоо

В. Холимог тогтолцоо　　Г. Пропорциональ тогтолцоо

**23. Нэр дэвшигч сонгогдохын тулд 50 хувиас дээш санал авсан байх ёстой. Үүнийг зарим үед "50+1 санал" гэж нэрлэдэг. Энэ нь сонгуулийн аль тогтолцоо вэ?**

А. Холимог тогтолцоо　　Б. Хувь тэнцүүлэх тогтолцоо

В. Харьцангуй олонхийн саналаар сонгох　　Г. Энгийн олонхийн саналаар сонгох

**24. Монгол улс хэдэн онд анх удаагаа сонгуулийн холимог системийн ашиглан сонгуулийг зохион байгуулсан бэ?**

А. 2008　　Б. 2012　　В. 2016　　Г. Аль нь ч биш

**25. Монгол улсын Иргэний хууль хэдэн онд батлагдсан бэ?**

А. 2001　　Б. 2002　　В. 2003　　Г. 2004

**26. Хувийн өмчийг " эцсийн зорилго бус эрх чөлөөг олж авах хэрэгсэл гэж үзсэн судлаач хэн бэ?**

А. Ж.Локк　　Б. Э. Фромм　　В. Дж. Кемпбелл　　Г. Н.Ротбард

**27. ......................... гэж хууль, дүрэм, журмыг зөрчсөн нийгэмд хор аюултай, хууль зүйн хариуцлага хүлээлгэх, шаардлагатай, гэм буруутай үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.**

А. Эрх зүйн зөрчил　　Б. Гэмт хэргийн зөрчил

В. Хууль зүйн зөрчил　　Г. Эрх, хууль зүйн зөрчил

**28. Ямар хуулиар төлбөрийн чадваргүй этгээдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхээр "Улсын өмгөөлөгч" хэмээх нэрийг томилж ажиллуулахаар болсон бэ?**

А. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай" хууль

Б. МУ-ын Үндсэн хууль　　В. Монгол улсын Иргэний хууль

Г. Хуульч, өмгөөлөгчийн тухай хууль

**29. Хүний эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн батлагааг бий болгох (үйлчилгээний хүртээмжийг амар хялбар болгох, эмзэг бүлгийг эн тэргүүнд анхаарч, тэгш байдлыг бүрдүүлэх) арга хэмжээг авна гэсэн үүрэг нь төрийн аль үүрэг вэ?**

А. Хүндэтгэх　　Б. Хангах

В. Хамгаалах　　Г. Ахиц дэвшилг гаргах

**30. Хүүхдийн эрхийн конвенц хэрхэн хэрэгжиж байгаад олон улсын хүүхдийн эрхийн хороо хяналт тавьж, гишүүн улсууд нь гэрээгээр хүлээсэн үүргээ ямар хэмжээнд биелүүлж байгаа талаар хэдэн жилд нэг удаа тайлан илтгэлээ гаргаж хэлэлцүүлдэг вэ?**

А. 2 жил　　Б. 4 жил　　В. 6 жил　　Г. 8 жил

**31. Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч өөрийн шаардлага ба татгалзлаа үндэслэж байгаа, шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, хуульд заасан арга хэрэгслээр олж авсан бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай аливаа баримт мэдээллийг.......................................................... хэлнэ**

А. Баримт Б. Нотлох баримт В. Гэрчлэх баримт Г. Улсын баримт

**32. Төр бол " хүний эрхийн гол дайсан" гэж хэн хэлсэн бэ?**

А.Т.Гоббс Б. Ф.Бастиа В. Р.Нозик Г. Ж.С.Милль

**33. Манай улсын тэргүүлэгч гуравдагч хөрш орон аль нь вэ?**

а. АНУ Б. Герман В. Хятад Г. ОХУ

**34. Олон улсын хөгжлийн агентлаг" ТИКА"-гийн шугамаар 1994 оноос эхлэн нийт 30 сая.ам долларын техникийн тусламж үзүүлсэн улс аль нь вэ?**

А. Япон Б. БНСУ В. Турк Г. Лаос

**35. Олон улсын байгууллагын үйл ажиллагааны цар хүрээний бүдүүвчийг гүйцээгээрэй.**




А. a-АСЕАН, b-АСЕМ Б. a-ШХАБ, b-АПЕК В. a-НАТО, b-НҮБ

Г. a-НАТО, b-ШХАБ

36. **"Хүний эрхийн" тухай дараах өгөгдлийг зөв тохируулна уу. /1 оноо/**

| | | | |
|---|---|---|---|
| A | Малала Юсуфзай | 1 | Миний 4 хүүхэд нэгэн өдөр арьсны өнгөөрөө бус, өөрийн чадвар,чадлаараа үнэлэгдэх тийм улсад амьдараасай |
| B | Мартин Лютер Кинг | 2 | Хүний эрх энгийн зүйлээс эхэлдэг |
| C | Элеанор Рузвельт | 3 | Нэг хүүхэд, нэг үзэг, нэг ном дэлхийг өөрчилж чадна |

А. А3,В1,С2, Б. А1,В3,С2, В. А1,В2,С3, Г. А2,В1,С3,

**37. Хүний эрхийг хамгаалах үндэсний болон олон улсын байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлүүдийг зөв харгалзуулна уу. /5 оноо/**

| | | | |
|---|---|---|---|
| A | НҮБ | 1 | Ерөнхий Ассамблей, Аюулгүйн зөвлөл, Эдийн засаг, нийгмийн зөвлөл, Хүний эрхийн комисс, Эмэгтэйчүүдийн байдлын тухай НҮБ-ын комисс |
| B | Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо | 2 | Олон улсын шүүх, Хүний эрхийн хороо, Хүүхдийн эрхийн хороо, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхалтыг устгах хороо |
| C | Хүний эрхийн зөрчил | 3 | Хүний эрхийг хангах, хамгаалах олон улсын тогтолцоог бүрдүүлэн ажиллах чиг үүргийг гүйцэтгэдэг |
| D | НҮБ-ын дүрэмд үндэслэгдсэн байгууллагууд | 4 | Үндэсний хууль тогтоомж, олон улсын болон бүс нутгийн гэрээ, конвенцоор болон бүс нутгийн гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүний эрхийг төр өөрийнхөө ямар нэгэн үйлдлээр зөрчсөн, эсхүл төрөөс хэрэгжүүлэх эдийн засаг, нийгэм, хууль зүйн үүрэг биелэгдээгүй байхыг хэлнэ. |
| E | Гэрээнд үндэслэгдсэн байгууллагууд | 5 | Монгол улсын Үндсэн хуульд зааснаар төр нь хүний эрхийн талаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийн тулд тодорхой байгууллага, тогтолцоог бүрдүүлэн ажилладаг. |

А. А4,В2,С1,D5,Е4 Б. А3,В5,С4,D1,Е2 В. А5,В4,С3,D2,Е1 Г. А2,В1,С5,D4,Е3

**38. Инфляцид холбогдох ойлголтуудыг зөв харгалзуулна уу. /5 оноо/**

| | | | |
|---|---|---|---|
| A | Эрэлтээс үүдэлтэй инфляци | 1 | Үйлдвэрлэлийн нөөцийн үнэ өссөнөөр уг бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ дагаж өсөх үзэгдэл |
| B | Зардлаас үүдэлтэй | 2 | Тухайн улсын эдийн засагт инфляцийн үзүүлэх нөлөө бага, түвшин нэг |

| | | | |
|---|---|---|---|
| | инфляци | | оронтой тоонд багтах үзэгдэл |
| C | Мөлхөө инфляци | 3 | Үнэ огцом түргэн бөгөөд жигд бусаар дээшилж байгаа нөхцөл. Тухайлбал инфляци 54.2 %-д хүрсэн |
| D | Цогио инфляци | 4 | Гүйлгээнд их хэмжээний мөнгө буй болсноос их хэмжээний мөнгө бага хэмжээний бүтээгдэхүүн, үйлчилгээнд ноогдох болсноор уг бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн дүн өсөх үзэгдэл |
| E | Гипер инфляци | 5 | Тухайн улсын эдийн засагт өндөр хурдтай инфляци бий болж нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө асар их, түвшин нь олон оронтой тоонд хүрэх үзэгдэл |

А. A4,B2,C1,D5,E4 Б. A4,B1,C2,D3,E5 В. A5,B4,C3,D2,E1 Г. A2,B1,C5,D4,E3

**39. Дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу. /5 оноо/**

| | | | |
|---|---|---|---|
| A | Хатуу хүч | 1 | Бусдад нөлөөлөх байдлаар өөрийн орны гадаад харилцааны бодлогыг сурталчлах, өөрийн орны талаар эерэг сэтгэгдэл бий болгох үйл ажиллагаа |
| B | Соёлын дипломат ажиллагаа | 2 | Ямар ч үед аль ч нөхцөлд ядарч зүдэрсэн эмзэг бүлгийн хүмүүсийн эрх ашгийг дээдэлж, тэдний ашиг сонирхлыг хүндэтгэсэн үйл ажиллагаа явуулахыг шийдвэр гаргагчид болон манлайлагчдад уриалах, ятган үнэмшүүлэх явдал |
| C | Эдийн засгийн дипломат ажиллагаа | 3 | Хоёр болон олон талт үйл ажиллагаанд тулгуурлан улс орныхоо худалдаа санхүүгийн ашиг сонирхлыг дипломат аргаар хангах явдал |
| D | Хүмүүнлэгийн дипломат ажиллагаа | 4 | Их гүрнүүд цэрэг, эдийн засгийн хүч чадавхдаа тулгуурлан хүчээр түрий барих бодлого хэрэгжүүлэх |
| E | Цахим дипломат ажиллагаа | 5 | Улсуудын харилцааг бэхжүүлэх, хамтын ажиллагааг бататгах буюу үндэсний эрх ашгаа хөхиүлэн дэмжих зорилгоор үзэл санаа, үнэт зүйл, уламжлал зэрэг бусад талуудын солилцоон дээр үндэслэдэг |

А. A4,B2,C1,D5,E4 Б. A3,B2,C1,D5,E4 В. A4,B5,C3,D2,E1 Г. A2,B1,C5,D4,E3

**40. Соёлын аялал жуулчлалын зарчим, төрлүүдийг ойлголтуудтай зөв харгалзуулна уу./5 оноо/**

| | | | |
|---|---|---|---|
| A | Орон нутгийн хүн амын амьжиргаа, нийгэм эдийн засгийн хөгжилд үр ашгаа өгөх | 1 | Олон улсын харилцаа, харилцан хүндэтгэл, ойлголцол, энх тайвнаар зэрэгцэн орших зорилгод эерэгээр нөлөөлнө |
| B | Байгалийн болон соёлын өвийн газруудтай харилцан шүтэлцээтэй хөгжүүлэх | 2 | Хөдөө орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлснээр хот руу чиглэх хүн амын урсгалыг багасгадаг |
| C | Байгалийн болон соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг бэхжүүлэх | 3 | Хөвсгөл нуур болон цаатангуудын соёлын өвүүдийг харилцан хамааралтай, хослуулан авч үзэх |
| D | Соёлын солилцоонд тулгуурлах | 4 | Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас иргэд гадагш гэхээсээ илүү орон нутаг дахь байгаль, түүх соёлын дурсгалт газруудаар аялах байдал нэмэгдсэн |
| E | Дотоодын аялал жуулчлал | 5 | Хөшөө цайдамын “Түрэгийн хүн чулууны түүхэн дурсгалт” газрыг Турк улсын дэмжлэгтэйгээр сэргээн засварласан |

А. A4,B2,C1,D5,E4 Б. A3,B2,C1,D5,E4 В. A2 B3,C5,D1,E4 Г. A2,B1,C5,D4,E3

**НИЙГМИЙН УХААН 11-Р АНГИЙН ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

**ХУГАЦАА: 80 МИНУТ**

**НИЙТ ОНОО: 40**

**D хувилбар**

1. **Ангийн ялгаа эрүүл мэндийн үйлчилгээ авах үйлдэл, хандлагын ялгаанд хүргэдэг болохыг нотолсон судлаач хэн бэ?**
   А. Ө. Күүс Б. Д.Датон В. Л.Козер Г. Е.О. Райт

2. **Нийгмийн гишүүд хувийн шинжээрээ зааглагдан хуваагдахыг юу гэдэг вэ?**
   А. Нийгмийн ялгарал Б. Тэгш бус байдал
   В. Нийгмийн давхраажилт Г. Нийгмийн давхраа
3. **Материаллаг баялгийн хэмжээ, эрхэлж буй ажил мэргэжлээр тодорхойлогддог, аж үйлдвэржилтийн харилцааны үр дүнд тогтсон, эдийн засгийн баялгийн ялгаанаас үүдэлтэй, харьцангуй нээлттэй буюу хувийн байр сууриа өөрчлөх боломжтой давхраажилтын хэв маяг аль нь вэ?**
   А. Боолчлол Б. Каст В. Язгуур угсаа Г. Анги бүлэг
4. **Тун бага хувийг эзэлдэг ч баялгийн дийлэнхийг эзэмшдэг. Энэ ангийн байр суурь нь үе залгамжилдаг гэсэн нь ямар ангийн талаар мэдээлэлж байна вэ?**
   А. Доод анги Б. Ядуу ажилчин анги В. Дээдийн дээд анги
   Г. Дундын дунд анги
5. **Нэг бүлгийхний зүгээс нөгөө бүлгээ тодорхойлдог үзэл бодол, хандлагыг юу гэдэг вэ?**
   А. Бурангүй үзэл Б. Алагчлал
   В. Тэгш бус байдал Г. Давхраажилт
6. **Хувь хүний бүтээлч сэтгэлгээ, ур чадвар, авьяас билгээс эх сурвалжтай, оюуны өмчөөр хамгаалагдсан соёлын агуулга бүхий бараа, бүтээл үйлдвэрлэх, тэдгээрийн хуваарилалт, нийлүүлэлтийн тогтолцоог хангасан үйлдвэрлэлийн салбарыг юу гэж тодорхойлдог вэ?**
   А. Соёлын үйлдвэрлэл Б. Соёлын даяаршил В. Соёлын адилсал
   Г. Соёлын дархлаа
7. **Соёлын аялал жуулчлалын баримталдаг зарчмуудаас илүүцийг ол.**
   А. Орон нутгийн хүн амын амьжиргаа, нийгэм, эдийн засгийн хөгжилд үр ашгаа өгөх
   Б. Байгалийн болон соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг бэхжүүлэх
   В. Соёлын солилцоонд тулгуурлах
   Г. Олон улсын харилцаа, харилцан хүндэтгэл, ойлголцол, энх тайвнаар зэрэгцэн орших зорилгод эерэгээр нөлөөлнө
8. **Зам харилцаа, эдийн засгийн харилцаа, мэдээлэл харилцааны хөгжлийн үндсэн дээр тусгаар соёлууд дэлхийн нэгдмэл соёлд нэгдэх үйл явцыг юу гэдэг вэ?**
   А. Соёлын үйлдвэрлэл Б. Соёлын даяаршил
   В. Соёлын адилсал Г. Соёлын дархлаа
9. **Соёлын дархлаа сулардаг гол шалтгаан юу вэ?**
   А. Бусдын соёлыг хуулбарлан дуурайх Б. Өөр соёлын зүгээс соёлын тулгалт хийх
   В. Соёлын нэвчих үзэгдэл давамгайлах Г. А ба Б хариулт зөв
10. **Хуурмаг эрх чөлөө нь хүнийг ганцаардуулж, хорвоо ертөнцөд итгэх юмгүй , айж хургасан нэгэн болгодог гэж үзсэн социологич хэн бэ?**
    А. Жон Локк Б. Дж.Кембелл В. Э.Фромм Г. Ф.Тённис

11. **Америк судлаач Ө. Күүс 1990-ээд онд нийгэм, эдийн засийн ялгаа бүхий гурван ангийг хүмүүс өөрсдийн өнгө шинж тэмдгийг хэрхэн тайлбарладаг болохыг судалсан. Доорх өгөгдлөөс хамааралгүй ангийг олно уу?**
    А Эдийн засгийн хувьд хамгийн амжилттай яваа анги
    Б. Цалингаараа амьдардаг дундаж хэсгийхэн

В. Бага орлоготой ажилчин анги

Г. Ур чадвараар бага даржин амьдралтай хэсгийнхэн

**12. Ядуу хүмүүс бодит хэрэгцээнээсээ бага эрүүл мэндийн үйлчилгээ авч байгаа нь нэгдүгээрт санхүүгийн боломж, хоёрдугаарт ядуусын соёл, гуравдугаарт нийгмийн институтийн саад бэрхшээлтэй холбоотой үзсэн социологич хэн бэ?**

А. Ө. Күүс Б. Д.Датон В. Л.Козер Г. Е.О. Райт

**13. Эдийн засгийн баялаг, нэр хүнд, эрх мэдэлд хүрэх адил бус боломж бүхий байдлыг юу гэх вэ?**

А. Нийгмийн ялгарал Б. Тэгш бус байдал

В. Нийгмийн давхраажилт Г. Нийгмийн давхраа

**14. Гол төлөв Азийн орнуудын давхраажилтад илэрдэг, шашны номлолоор зөвтгөгдөн, хөдөлмөрийн хуваарьтай нь холбогдон тодорхойлогдсон, хувийн байр суурийг өөрчлөх ямар ч боломжгүй уламжлалт хаалттай давхраажилтын тогтолцоо аль нь вэ?**

А. Боолчлол Б. Каст В. Язгуур угсаа Г. Анги – бүлэг

**15. Давхраажилтын дараах хэмжигдэхүүнээс эрх мэдлийн төрөлд аль нь хамаарах вэ?**

А. Үл хөдлөх хөрөнгө эзэмших Б. Бусдад нөлөөлөх, дагуулах

В. Хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт, үнэ цэн Г. Онцгой авьяас чадвар

**16. Үндэсний соёлын өвөрмөц өв санг дэлхий нийтэд үзүүлэн таниулах хэрэгцээ улам нэмэгдэж байгаа өнөө үеийн соёлын солилцооны гол хөтлөх хүч нь дотоодын болон олон улсын........................................... мөн.**

А. Соёлын аялал жуулчлал Б. Соёлын үйлдвэрлэл В. Соёлын даяаршил

Г. Соёлын дархлаа

**17. Тухайн цаг үеийн хүчирхэг гүрнүүдийн зүгээс бага буурай улс оронд хандсан үйлдэл бөгөөд бүтээсэн бүхнийг устгаж, хүнийг тэр зүйлээ дахин бүтээхгүй болтол нь айлган сүрдүүлэх үйл явц нь соёлын харилцан үйлчлэлийн ямар хэлбэр вэ?**

А. Соёлын давамгайлал Б. Соёлын соёлын солилцоо

В. Соёлыг хуулбарлан дуурайх Г. Соёлын тулгалт

**18. Манай судлаачид юуг "соёлын ижилсэл"," соёлын өөрийншил"," соёлын өвөр төрх" гэх зэргээр нэрлэх нь бий вэ?**

А.Соёлын орон зай Б. Соёлын даяаршил В. Соёлын адилсал

Г. Соёлын дархлаа

**19. Хүнд төрөлхөөс заясан гурван эрх байна. Энэ нь амьдрах эрх, эрх чөлөөтэй байх, өмчлөх эрхтэй гэж заасан социологич хэн бэ?**

А. Жон Локк Б. Дж.Кембелл В. Э.Фромм Г. Ф.Тённис

**20. Харийн соёлд дасан зохицох хэдэн үе шат байдаг вэ?**

А. 5 Б. 6 В. 7 Г. 8

**21. Америкийн судлаач Ө.Күүс 1990-ээд онд нийгэм, эдийн засгийн ялгаа бүхий гурван ангийн хүмүүс өөрсдийн өвчний шинж тэмдгийг хэрхэн тайлбарладаг болохыг судалжээ. Тэрээр нэг дэх ангид эдийн засаг, санхүүгийн хувьд хамгийн амжилттай байгаа, хоёр дахь ангид цалингаараа амьдардаг дундаж хэсгийнхнийг,гурав дахь ангид ур чадвар бага, даржин амьдралтай хэсгийхнийг багтаасан. Нэг дэх ангийн хүмүүсийн хандлага аль нь вэ?**

А. Өвчний нэг шинж тэмдэг илрэхэд эмчид хандаж эрүүл мэндийн үйлчилгээ авахаар эрэлхийлдэг

Б. 17 шинж тэмдгийн 10 шинж тэмдгийг эмнэлэгт үзүүлэх ноцтой шинж биш гэж үздэг

В. Өвчний шинж илрээгүй байсан ч эмнэлэгийн хяналтанд тогтмол байдаг

Г. Санхүүгийн хувьд санаа зоволтгүй тул өвчин эмгэг тусдаггүй

**22. Үйлдвэрт ямар машин техник авах вэ гэдгийг шийдэхэд жирийн ажилчин хүн оролцох боломжоор хомс бол инженер техникийн ажилтан, менежрүүдийн хувьд саналаа илэрхийлэх, цаашлаад шийдвэр гаргахад шууд оролцож байдаг. Энэ нь байр суурийн ямар өгөгдлийг өөртөө илүү агуулж байна вэ?**

А. Хэр зэрэг эрх мэдэлтэй вэ гэдгээс хамааран
Б. Ямар байр суурь эзэлж байгаагаасаа хамаарч
В. Ямар баялаг эзэмшиж байгаагаас хамаарч
Г. Алдар хүнд, хүндэтгэлийн зэргээс хамаарч

23. **Тодорхой хэв шинжит харилцаа бүхий тэгш бус байдлын тогтолцоог юу гэдэг вэ?**
А. Нийгмийн ялгарал Б. Тэгш бус байдал
В. Нийгмийн давхраажилт Г. Нийгмийн давхраа

24. **К.Марксын үйлдвэрлэлийн хэрэгсэлтэй харилцах харилцаа (өмч) –ны ялгарлыг чухалчилсан үзэл санааг үйлдвэрлэлийн харилцаан дахь М.Веберын "хянах" эрх мэдлийн үзэл санаагаар баяжуулсан судлаач аль нь вэ?**
А. Ө. Күүс Б. Д.Датон В. Л.Козер Г. Е.О. Райт

25. **Дайн байлдаан, өр төлөөс эсвэл төрийн үзэл суртлын үр дүнд үүсдэг, нэг нь нөгөөгийнхөө өмч нь болж байдаг, албадлагын хөдөлмөрийн харилцаанд тулгуурласан, байр сууриа өөрчлөх боломжоор хомс хаалттай тогтолцоо, давхраажилтын хэв маяг аль нь вэ?**
А. Боолчлол Б. Каст В. Язгуур угсаа Г. Анги-бүлэг

26. **Соёлын үйлдвэрлэл хэмээх ойлголт анх хэдэн онд гарч ирсэн бэ?**
А. 1950-аад он Б. 1960-аад он В. 1970-аад он Г. 1980-аад он

27. **Соёлын аялал жуулчлалын баримталдаг зарчмуудаас илүүцийг ол.**
А. Орон нутгийн хүн амын амьжиргаа, нийгэм, эдийн засгийн хөгжилд үр ашгаа өгөх
Б. Байгалийн болон соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг бэхжүүлэх
В. Соёлын солилцоонд тулгуурлах
Г. Олон улсын харилцаа, харилцан хүндэтгэл, ойлголцол, энх тайвнаар зэрэгцэн орших зорилгод эерэгээр нөлөөлнө

28. **Бүх шатны сургуульд англи хэлийг зааж байна. Англи, хятад, орос япон, солонгос хэлний сургалтын төв, сургуулиуд олширч байна. Бизнесийн байгууллагуудын ажлын байрны тодорхойлолтыг үзэхэд гадаад хэлний боловсрол хамгийн чухалд тооцогдож байна гэх мэт нь ямар ойлголтыг илэрхийлж байна.**
А. Соёлын үйлдвэрлэл Б. Соёлын даяаршил
В. Соёлын адилсал Г. Соёлын дархлаа

29. **Манай судлаачид юуг "соёлын ижилсэл"," соёлын өөрийншил"," соёлын өвөр төрх" гэх зэргээр нэрлэх нь бий вэ?**
А.Соёлын орон зай Б. Соёлын даяаршил
В. Соёлын адилсал Г. Соёлын дархлаа

30. **Соёлын дархлаа сулардаг гол шалтгаан юу вэ?**
А. Бусдын соёлыг хуулбарлан дуурайх
Б. Өөр соёлын зүгээс соёлын тулгалт хийх
В. Соёлын нэвчих үзэгдэл давамгайлах
Г. А ба Б хариулт зөв

31. **Монгол улс Америкийн нэгдсэн улстай хэдэн онд дипломат харилцаа тогтоосон бэ?**
А. 1985 он Б. 1986 он В. 1987 он Г. 1989 он

32. **Албадлага, урамшууллаар бус харин бусад улсын сэтгэлийг өөртөө татах замаар өөрийн хүсэж буй үр дүнд хүрэхийн тулд бусдад нөлөөлөх чадварыг юу гэдэг вэ?**
А. Зөөлөн хүчний бодлого Б. Хатуу хүчний бодлого
В. Ухаалаг хүчний бодлого Г. Цахим хүчний бодлого

33. **Хатуу хүчний шинжүүдээс илүүцийг ол.**
А. Албадлага Б. Цэргийн хүч
В. Эдийн засгийн хориг Г. Сэтгэл татам байдал

34. **Хүнлэг байх ёс суртахууныг эрхэмлэн ямар ч үед, аль ч нөхцөлд ядарч зүдэрсэн эмзэг бүлгийн хүмүүсийн эрх ашгийг дээдэлж, тэдний ашиг сонирхлыг хүндэтгэсэн үйл ажиллагаа явуулахыг шийдвэр гаргагчид болон манлайлагчдад уриалах, тэднийг ятган, үнэмшүүлэх нь ямар дипломат ажиллагаа вэ?**

А. Ардын дипломат Б.Цахим димломат В. Соёлын дипломат
Г. Хүмүүнлэгийн дипломат

**35. 1991 онд Персийн булангийн үйл явцын талаар CNN дайны талбараас шуурхай мэдээ хүргэснээр дэлхийн улс орнуудад бодит мэдээллийг газар дээрээс нь шууд хүргэх эхлэл болсон гэх мэдээлэл улс бус оролцогчдын ямар ангилал нь вэ?**

А. Шашны бүлэг Б. ОУ-ын хэвлэл мэдээллийн хэрэгсэл
В. Үндэстэн дамнасан корпорац Г. ТББ

**36. Монгол Монгол улстай түншлэлийн харилцаатай улсуудыг харуулсан бүдүүвчийг гүйцээгээрэй.**




**А. a-Стратегийн түншлэл, b-Энэтхэг Б. a-Иж бүрэн стратегийн түншлэл, b-БНХАУ**
**В. a-Стратегийн түншлэл, b-БНСУ Г. a-Иж бүрэн түншлэл, b-АНУ**

**37. ДНБ-ий үзүүлэлтийг тодорхойлолттой нь харгалзуулна уу.**

| | | | |
|---|---|---|---|
| a | Бодит ДНБ | 1 | Дотоод болон хилийн чанад дахь Монголын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжүүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг |
| b | Нэрлэсэн ДНБ | 2 | Тухайн жилийн бараа бүтээгдэхүүнийг өнөөгийн үнээр тооцохыг хэлнэ |
| c | Үндэсний нийт бүтээгдэхүүн | 3 | Тухайн жилийн бараа бүтээгдэхүүнийг тогтмол үнээр тооцох үзүүлэлт |
| d | Дотоодын нийт бүтээгдэхүүн | 4 | Тухайн оны ДНБ-ийг өмнөх оны ДНБ-д харьцуулаад 100 хувьд үржүүлж тооцоолно. |
| e | ДНБ-ийн өсөлтийг тооцох | 5 | Тухайн улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн, эцсийн бараа, үйлчилгээний зах зээлийн үнийн дүн |

А. A3,B2,C1,D5,E4 Б. A5,B3,C1,D4,E2 В. A5,B4,C3,D2,E1 Г. A2,B1,C5,D4,E3

**38. Д. Истоны улс төрийн системийн ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу.**

| | | | |
|---|---|---|---|
| a | Шаардлага | 1 | Аль нэг нам, нэр дэвшигчийн төлөө санал өгөх, шийдвэрийг дэмжиж буйгаа илэрхийлэх |
| b | Оролцооны дэмжлэг | 2 | Улс төрийн системийн дотроос эсвэл, түүнийг хүрээлэн байгаа экологи, эдийн засаг, соёл зэрэг янз бүрийн системүүдээс гарч буй тулгалтууд |
| c | Бодит дэмжлэг | 3 | Нийгмийн хурцадмал, тогтворгүй байдлыг арилгах гол механизмын үүргийг гүйцэтгэдэг онцлогтой |
| d | Шийдвэр | 4 | Төрийн бодлогын тодорхой илрэл болсон төрийн хууль тогтоомж, мэдээлэл, сурталчилгаа гэх мэт |
| e | Эргэх холбоо | 5 | Татвар төлөх, төрийн болон цэргийн алба хаших, хууль дүрмийг дагаж мөрдөх |

А. A3,B2,C1,D5,E4 Б. A5,B3,C1,D4,E2 В. A5,B4,C3,D2,E1 Г. A2,B1,C5,D4,E3

**39. Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх хугацааг харгалзуулна уу.**

| | | | |
|---|---|---|---|
| a | Гомдол хүлээн авсан шүүх хэрэгт улсын тэмдэгтийн хураамж төлсөн | 1 | 30 хоног |

| | | | |
|---|---|---|---|
| | баримт, хэргийн оролцогчдын гомдлыг хавсарган гомдлыг хүлээж авсан өдрөөс хойш нийслэлд .......... дотор улсын дээд шүүхэд хүргүүлнэ. | | |
| b | Шүүгч нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш ....... дотор хэрэг үүсгэх тухай захирамж гаргана. | 2 | 90 хоног |
| c | Хэрэг үүссэн өдрөөс хойш орон нутагт ........ дотор шүүх нэхэмжлэлийг хариуцагчид гардуулна. | 3 | 14 хоног |
| d | Давж заалдах гомдол гаргасан хэргийг, давж заалдах шүүх хүлээн авснаас хойш ......... дотор хянан шийдвэрлэнэ. | 4 | 3 хоног |
| e | Зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хугацаа хэтэрсэн тохиолдолд гомдол хүлээн авсан захиргааны байгууллага, албан тушаалтан хугацаа хэтэрснээс хойш ...... дотор нөхөн сэргээнэ. | 5 | 7 хоног |

А. A3,B2,C1,D5,E4 Б. A5,B3,C1,D4,E2 В. A5,B4,C3,D2,E1 Г. A4,B5,C3,D1,E2

**40. Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллага, бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудыг харгалзуулна уу.**

| | | | |
|---|---|---|---|
| a | UNDP | 1 | НҮБ-ын “Хөгжлийн хөтөлбөр” |
| b | UNESCO | 2 | Ази номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга |
| c | АСЕАН | 3 | НҮБ-ын “Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага” |
| d | АПЕК | 4 | Зүүн өмнөд Азийн орнуудын холбоо |
| e | АСЕМ | 5 | Ази-Европын уулзалт |

А. A3,B2,C1,D5,E4 Б. A1,B3,C4,D2,E5 В. A5,B4,C3,D2,E1 Г. A2,B1,C5,D4,E3

## НИЙГМИЙН УХААН 11-Р АНГИЙН ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

**ХУГАЦАА: 80 МИНУТ**

**НИЙТ ОНОО: 40**

**Е хувилбар**

1. **Татвар хураалтын үндсэн зарчмуудыг тодорхойлсон зах зээлийн онолыг үндэслэгч хэн бэ?**
   А. А.Смит Б. А.Маршалл В. Ж.Кейнс Г. Д.Рикардо

2. **Эдгээрээс аль нь Ж.Кейнсийн үзэл санаанд хамаарахгүй вэ?**
   А. Зах зээлийн тогтолцоо нь эдийн засгийн уналтаас өөрийгөө аварч үл чадна.
   Б. Төрийн оролцоотойгоор нийт эрэлтийг нэмэгдүүлэх замаар эдийн засагт зохицуулалт хийх нь үр ашигтай.
   В. Зах зээлийн харилцаа нь "үл үзэгдэгч гар"-ын онолын дагуу явагдвал илүү үр дүнд хүрнэ.
   Г. Нийт эрэлтийг нэмэгдүүлэхдээ төрийн худалдан авалтын зардлыг аль болох чухалд үзэх хэрэгтэй.
3. **Улс орнуудын хооронд бараа, үйлчилгээ шилжих хөдөлгөөнийг ............................. гэнэ.**
   А. Гадаад худалдааны тэнцэл Б. Гадаадын шууд хөрөнгө оруулалт
   В. Олон улсын худалдаа Г. Гадаад худалдааны бараа эргэлт
4. **Төр татвараас гадна тодорхой төрлийн барааны импорт хязгаарлалт буюу квот тогтоож өгөх тохиолдол байдаг. Жишээ: Тухайн оронд жил орох барааны тоо хэмжээг 20 мянган ширхэгээс хэтрүүлэхгүй байх гэх мэт. Ийм арга хэмжээг гадаад худалдааны ямар бодлого гэж нэрлэдэг вэ?**
   А. Капиталын бодлого Б. Демпинг В. Санхүү мөнгөний бодлого
   Г. Протекционист бодлого
5. **Дэлхийн улс орнуудын хооронд бүтээгдэхүүн солилцох явцад үүсэж байгаа харилцааг.......................... гэнэ.**
   А. Олон улсын зах зээл Б. Дэлхийн зах зээл
   В. Дэлхийн худалдаа Г. Дэлхийн интеграци
6. **"Тогтвортой хөгжил"-ийн үзүүлэлтэнд илүүц зүйл байна уу?**
   А. Бичиг үсэгт тайлагдсан байдал Б. Эдийн засаг
   В. Байгаль орчин Г. Нийгмийн байдал
7. **Үндэстэн дамнасан корпораци аль нь вэ?**
   А. Бусад улс орнууудтай тогтоосон худалдааны харилцааг зохицуулах зорилгоос төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нийлбэр цогц
   Б. Гадаад орнуудад хоёр болон түүнээс олон үйлдвэрлэл, үйлчилгээний салбартай компани
   В. Бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэр байгуулах эсвэл худалдан авах
   Г. Үйлвэрлэгчид гадаад орнуудын шинэ зах зээлд нэвтрэхийн тулд өрсөлдөгчөөсөө доогуур үнээр бараагаа шахаж дараа нь үнэ өсгөх зорилготой түр зуурын үзэгдэл
8. **Иргэний нийгэм нь төрөөс үл хамаарах өөр хоорондын харилцаа, эрх зүйгээр зохицуулагддаг хувь хүмүүс, анги бүлэг, институтуудын нийлбэр цогц юм гэж хэн хэлсэн бэ?**
   А. И.Кант Б. Г.Гегель В. Р.Дарендорьф Г. Р.Путнам
9. **.................... гэдэг нь хоёр ба түүнээс дээш тооны нэр дэвшигч, улс төрийн нам, эвслээс иргэн хүн тэгш эрхтэйгээр сонголтоо өөрийн биеэр, чөлөөтэй хийж, үр дүн нь шууд гардаг улс төрийн сонголт юм**
   А. Төр Б. Нам В. Сонгууль Г. Засаглал

10. **Сонгуулийн чөлөөтэй сонгох зарчимд хамаарах өгөгдөл аль нь вэ?**
   А. Нас хүйс, яс үндэс, гарал угсаа, мэргэжил, хэл, санхүүгийн чадвараас үл шалтгаалан бүгд оролцох
   Б. Сонгогч бүр ижил тооны санал гаргах эрхтэй бөгөөд санал бүр адил жинтэй байх
   В. Сонгогч ямар нэгэн дарамт шахалтгүйгээр гагцхүү өөрийн үзэмжээр саналаа өгөх явдал

Г. Сонгуульд оролцохдоо чөлөөт сонголтоо хийн, саналаа чөлөөтэй илэрхийлэх бүхий л бололцоогоор хангагдах ѐстой.

11. **Хуулийн дагуу,тогтоогдсон хэмжээгээр бүх хүн, хуулийн этгээдээс төрд заавал төлөх, буцалтгүй шинжтэй хураамжыг юу гэдэг вэ?**
А. Татвар Б. Хураамж В. Төлбөр
Г. Шимтгэл

12. **Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх бодлогыг юу гэдэг вэ?**
А. Улсын төсөв Б. Төсвийн бодлого
В. Сангийн бодлого Г. Төрийн мөнгө, зээлийн бодлого

13. **Валютын интервенци хэмээх ойлголтыг илэрхийлсэн тодорхойлолтыг доорх өгөгдлүүдээс сонгоно уу.**
А. Гадаадын нэгж валютыг өөрийн валютаар худалдан авах үнэ
Б. Төв бакнаас валютын ханшийг өсгөх үйл ажиллагаа
В. Төв бакнаас валютын ханшийг бууруулах үйл ажиллагаа
Г. Төв банк өөрийн нөөцөөр валютыг худалдан авах үйл ажиллагаа

14. **Демпингийн үйл ажиллагаа гэж юу вэ?**
А. Импортын бараанд үнэ тарифийн хязгаарлалт хийх үйл ажиллагаа
Б. Импортын барааны тоо хэмжээнд нь хязгаар тогтоох үйл ажиллагаа
В. Импортлож байгаа бараанд татвар ноогдуулах үйл ажиллагаа
Г. Бараа, үйлчилгээг гадаад зах зээлд нэвтрүүлэхийн тулд өрсөлдөгчөөсөө доогуур үнээр худалдаалах үйл ажиллагаа

15. **Гадаадын шууд хөрөнгө оруулалт аль нь вэ?**
А. Гадаад орнуудад хоёр болон түүнээс олон үйлдвэрлэл, үйлчилгээний салбартай компани
Б. Бусад улс орнууудтай тогтоосон худалдааны харилцааг зохицуулах зорилгоос төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нийлбэр цогц
В. Бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэр байгуулах эсвэл худалдан авах
Г. Тухайн орны үнэт цаасыг гадаадын худалдан авагчдад худалдана

16. **Нэг хүнд ногдох Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт нь.............харуулдаг.**
А. Тухайн улсын эдийн засгийн чадавхийг харуулдаг
Б. Тухайн улсын иргэдийн амьдралын түвшинг харуулдаг
В. Тухайн улсын экспортын нийт хэмжээг харуулдаг
Г. Тухайн улсын экспорт, импортын зөрүүг харуулдаг

17. **НҮБ-аас хүний хөгжлийн индексийг дараах гурван үзүүлэлтээр тодорхойлдог. Гүйцээж бичнэ үү**
1. Хүн амын дундаж наслалт 2. Нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ 3.................
А. Нийгмийн байдал Б. Хүн амын орлогын түвшин В. Эдийн засаг
Г. Боловсролын түвшин

18. **"Аливаа зүйлийг хийж бүтээнэ гэдэг нь өчүүхэн ч атугай бусадтай чөлөөтэй хамтран ажиллана гэсэн үг. Энэ нь чөлөөт эвсэл холбоо болон байгууллагуудын сүлжилсэн ертөнц болж дараа нь бие даасан институтууд бий болоход хүргэдэг" гэж хэн хэлсэн бэ?**
А. И.Кант Б. Г.Гегель В. Р.Дарендорьф Г. Р.Путнам

19. **Сонгогдох эрхийн шалгуурт хамааралгүй зүйл аль нь вэ?**
А. Гадаадад дээд боловсрол эзэмшсэн байх
Б. Сүүлийн 5 жил эх орондоо тогтвор суурьшилтай амьдарсан
В. УИХ-ын гишүүнд нэр дэвшихэд 25 нас хүрсэн байх
Г. Ерөнхийлөгчид нэр дэвшихэд 45 нас хүрсэн байх

20. **Ардчилсан сонгуулийн зарчимд хамаарахгүй өгөгдөл аль нь вэ?**
А. Бүх нийтээр оролцох зарчим Б. Заавал саналаа өгөх зарчим
В. Тэгш оролцох зарчим Г. Саналыг шууд өгөх зарчим

21. **Төсвийн хомсдолыг юу гэдэг вэ?**
А. Интервенц Б. Демпинг В. Дефицит Г. Профицит

**22. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх бодлогыг төрийн сангийн буюу .......гэж нэрлэдэг.**

А. Улсын төсөв Б. Төсвийн бодлого

В. Сангийн бодлого Г. Төрийн мөнгө, зээлийн бодлого

**23. Мөнгөний бодлогын үндсэн арга хэмжээнүүдийг ....................... бүрэн эрхийнхээ хүрээнд дангаар, бие даан хэрэгжүүлдэг бол төсвийн орлого, зарлагын аливаа нэгэн өөрчлөлтийг ..................... дээр хэлэлцэж байж шийдвэр гаргадаг учраас мөнгөний бодлого нь сангийн бодлогыг бодвол илүү уян хатан чанартай байна.**

А. Монгол банк, УИХ Б. Төв банк, Засгийн газар

В. Төв банк, УИХ Г. Банк, УИХ

**24. Гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ болон үнийн түвшний хооронд шууд холбоо байхгүй бөгөөд төрийн идэвхтэй оролцоо нь эдийн засагт хор учруулна гэж хэн үзсэн бэ?**

А. Ж.Локк Б. Э. Фромм В. Хайек Г. Н.Ротбард

**25. Валютын интервенци хэмээх ойлголтыг илэрхийлсэн тодорхойлолтыг доорх өгөгдлүүдээс сонгоно уу.**

А. Гадаадын нэгж валютыг өөрийн валютаар худалдан авах үнэ

Б. Төв бакнаас валютын ханшийг өсгөх үйл ажиллагаа

В. Төв бакнаас валютын ханшийг бууруулах үйл ажиллагаа

Г. Төв банк өөрийн нөөцөөр валютыг худалдан авах үйл ажиллагаа

**26. Гадаад худалдааны бодлого гэдэг ойлголтыг аль өгөгдөл нь зөв илэрхийлж байна вэ?**

А. Улс орнуудтай тогтоосон худалдааны харилцааг зохицуулах зорилгоор төрөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нийлбэр цогц үйл ажиллагаа

Б. Бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэрлэлээ байгуулах эсвэл худалдан авах үйл ажиллагаа

В. Гадаад орнуудад хоёр болон түүнээс олон үйлдвэрлэл, үйлчилгээний салбартай томоохон компаниудын үйл ажиллагаа

Г. Аль болох олон улс оронтой харилцан ашигтай байдлаар гадаад худалдаа, харилцаагаа өргөжүүлэн явуулах үйл ажиллагаа

**27. Портфелийн хөрөнгө оруулалт аль нь вэ?**

А. Компани бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэр байгуулах, эсвэл худалдан авна

Б. Тухайн орны үнэт цаасыг гадаадын худалдан авагчдад худалдана

В. Үйлвэрлэгчид гадаад орнуудын шинэ зах зээлд нэвтрэхийн тулд өрсөлдөгчөөсөө доогуур үнээр бараагаа шахаж дараа нь үнэ өсгөх зорилготой түр зуурын үзэгдэл

Г. Хилийн чанадад тухайн орны үндэсний валютын нийлүүлэлтийг бий болгоно.

**28. “ Төр, эдийн засаг, гэр бүлээс ангид орших нийгмийн хүрээг иргэний нийгэм гэнэ” хэн хэлсэн бэ?**

А. И.Кант Б. Г.Гегель В. Р.Дарендорьф Г. Р.Путнам

**29. XVII зуунаас баруун Европт төрийн эрх мэдэл гагцхүү ард түмнээс, тэдний итгэл, зөвшөөрлөөс үүсэлтэй гэсэн үзэл баримтлал давамгайлах болсон. Францын болон Америкийн хувьсгалаар иргэн бүр тэгш эрхтэй хэмээн тунхаглаж, энэ үеэс л хууль тогтоох байгууллагад нийгмийн янз бүрийн төлөөллийг сонгох болжээ. Уг мэдээлэл юуны талаар илүү онцолсон бэ?**

А. Төр Б. Нам В. Сонгууль Г. Засаглал

**30. Саналаа нууцаар гаргах зарчим аль нь вэ?**

А. Нас хүйс, яс үндэс, гарал угсаа, мэргэжил, хэл, санхүүгийн чадвараас үл шалтгаалан бүгд оролцох

Б. Сонгогч бүр ижил тооны санал гаргах эрхтэй бөгөөд санал бүр адил жинтэй байх

В. Сонгогч ямар нэгэн дарамт шахалтгүйгээр гагцхүү өөрийн үзэмжээр саналаа өгөх явдал

Г. Сонгуулийн эцсийн үр дүн нь зөвхөн иргэдийн санал хураалтын үр дүнгээр шийдэгддэг.

**31. Дорнод аймгийн шүүх нь ............................. шүүх юм.**

А. Сум, сум дундын шүүх Б. Аймаг, нийслэлийн шүүх

В. Улсын дээд шүүх Г. Хяналтын шатны шүүх

32. **Хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэгч, механизмыг тогтоосон олон улсын хүний эрхийн 4 баримт бичгийг................... гэнэ.**
А. Хүний эрхийн тунхаглал　　Б. Хүний эрхийн нэмэлт протокол
В. Хүний эрхий билл　　Г. Олон улсын хүний эрхийн билл

33. **Засгийн газрын оролцоо дэмжлэггүйгээр улс үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулдаг глобал түвшний оролцогчид, тоглогчид олон улсын байгууллагыг хамруулан үздэг ойлголтыг юу гэдэг вэ?**
А. Олон улсын харилцаанд оролцогч　　Б. Улс бус оролцогч
В. Зөөлөн хүчний бодлого　　Г. Хатуу хүчний бодлого

34. **ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол улсын гадаад харилцааны бодлогын.......................... мөн.**
А. Хоёр дахь зорилт　　Б. Эн тэргүүний зорилтВ. Гурав дахь зорилт
Г. Дөрөв дэх зорилт

35. **Монгол улс иж бүрэн стратегийн түншлэлээр ямар улстай харилцдаг вэ?**
А. Хятад　　Б. ОХУ　　В. АНУ　　Г. Солонгос улс

36. **Дараах бүдүүвчийг ажиглаад соёлын харилцан үйлчлэлийн хэлбэрийг гүйцээгээрэй.**




А. Соёлыг тулгалт　　Б. Соёлын цочирдол　　В. Соёлын солилцоо
Г. Соёлын эрх чөлөө

37. **ДНБ-ний үзүүлэлтийг тодорхойлолттой нь харгалзуулна уу.**

| | | | |
|---|---|---|---|
| a | Бодит ДНБ | 1 | Тухайн улсын хэмжээнд жилийн турш үйлдвэрлэсэн баялгийн орлогын нийлбэр дүн |
| b | Нэг хүнд ногдох ДНБийн өсөлт | 2 | Хэрэглэгчдийн эцсийн хэрэглээндээ зориулан худалдан авахад зарцуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлбэр |
| c | Бодит ДНБ-ийн өсөлт | 3 | Тухайн улсын улсын эдийн засгийн чадавхыг харуулдаг. |
| d | ДНБ-ийг зардлаар тооцох | 4 | Тухайн улсын иргэдийн амжиргааны түвшинг илтгэнэ. |
| e | ДНБ-ийг орлогоор тооцох | 5 | Тухайн жилийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн түвшний ерөнхий өсөлт буюу инфляцийн түвшинд харьцуулж тодорхойлно. |

А. A3,B2,C1,D5,E4　　Б. A1,B3,C4,D2,E5　　В. A5,B4,C3,D2,E1　　Г. A2,B1,C5,D4,E3

38. **Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу.**

| | | | |
|---|---|---|---|
| a | Оролтод хамаарах шаардлага | 1 | Төрийн бодлогын тодорхой илрэл болсон төрийн хууль тогтоомж, мэдээлэл, сурталчилгаа гэх мэт |
| b | Оролцооны дэмжлэг | 2 | Төрийн албан ёсны мэдээлэл, бэлгэдлийг хүндэтгэх |
| c | Бодит дэмжлэг | 3 | Тодорхой бодлого, шийдвэрийг дэмжиж буйгаа илэрхийлэх |
| d | Үйлдэл | 4 | Улс төрийн системийн дотроос эсвэл, түүнийг хүрээлэн байгаа экологи, эдийн засаг, соёл зэрэг янз бүрийн системүүдээс гарч буй тулгалтууд |
| e | Эргэх холбоо | 5 | Улс төрийн системд хувьсан өөрчлөгдөж буй орчинд зохицох, шинэчлэх, өөрийгөө хадгалах боломцоог олгодо |

А. A4,B3,C2,D1,E5　　Б. A1,B3,C4,D2,E5　　В. A5,B4,C3,D2,E1　　Г. A2,B1,C5,D4,E3

39. **Бүрэн тэтгэвэр тогтоолгох үндэс болон нийгмийн даатгалын сангаас олгодог тэтгэмжүүдийг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /5 оноо/**

| | | | |
|---|---|---|---|
| a | Бүрэн тэтгэвэр тогтоолгох үндэслэл | 1 | Нийгмийн даатгалын шимтгэлийг 3 болон түүнээс дээш сарын хугацаагаар төлсөн байх |
| b | Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох нөхцөл | 2 | Нийгмийн даатгалын шимтгэлийг 20-оос доошгүй жил төлсөн 60 насанд хүрсэн эрэгтэй, 55 насанд хүрсэн эмэгтэй |
| c | Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж олгох нөхцөл | 3 | Нийгмийн даатгалын шимтгэлийг 36 сараас доошгүй хугацаагаар төлсөн байх |
| d | Оршуулгын тэтгэмж олгох нөхцөл | 4 | Нийгмийн даатгалын шимтгэлийг 12 сар төлсөн, сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн байх |
| e | Ажилгүйдлийн тэтгэмж олгох нөхцөл | 5 | Нийгмийн даатгалын шимтгэлийг 24 сараас доошгүй хугацаанд төлсөн, сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн байх |

А. A2,B1,C4,D3,E5　　Б. A1,B3,C4,D2,E5　　В. A5,B4,C3,D2,E1　　Г. A2,B1,C5,D4,E3

**40. Нэгдсэн Үндэсний Байгууллагын төрөлжсөн байгууллага, бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудыг харгалзуулна уу.**

| | | | |
|---|---|---|---|
| a | UNESCO | 1 | 1957 онд Ромын гэрээгээр байгуллагадсан |
| b | ШХАБ | 2 | Шанхайн хамтын ажиллагааны байгууллага |
| c | Европын холбоо | 3 | НҮБ-ын “Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага” |
| d | ACEM | 4 | Нэгдсэн үндэсний байгууллагын “Хүүхдийн сан” |
| e | UNICEF | 5 | Ази-Европын уулзалт |

А. A4,B2,C1,D5,E4　　Б. A3,B2,C1,D5,E4　　В. A5,B4,C3,D2,E1　　Г. A2,B1,C5,D4,E3

Хариулт

| № | A | B | C | D | E |
|---|---|---|---|---|---|
| 1 | А | В | А | А | А |
| 2 | А | Б | Б | А | В |
| 3 | Г | Б | В | Г | В |
| 4 | В | Б | Г | В | Г |
| 5 | А | Б | А | А | Б |
| 6 | А | А | Г | А | А |
| 7 | Г | Г | Г | Г | Б |
| 8 | Б | В | Б | Б | Б |
| 9 | Г | А | В | Г | В |
| 10 | В | В | Г | В | Г |
| 11 | А | А | В | В | А |
| 12 | В | Г | Б | Б | Г |
| 13 | В | Г | В | Б | Г |
| 14 | Г | Г | В | Б | Г |
| 15 | Б | В | Г | Б | В |
| 16 | А | Б | А | А | Б |
| 17 | Б | Г | А | Г | Г |
| 18 | Б | В | Г | В | В |
| 19 | В | А | В | А | А |
| 20 | Г | Б | В | В | Б |
| 21 | А | Б | Б | А | В |
| 22 | А | Б | А | Б | Б |
| 23 | А | Б | Г | В | В |
| 24 | Г | Б | Б | Г | В |
| 25 | Г | Б | Б | А | Г |
| 26 | Б | Б | А | Г | А |
| 27 | Г | А | А | Г | А |
| 28 | Б | Г | А | Б | Г |
| 29 | Б | А | Б | В | В |
| 30 | А | В | Б | Г | В |
| 31 | Б | Г | Б | В | Б |
| 32 | В | А | В | А | В |
| 33 | В | Б | А | Г | В |
| 34 | Б | Б | В | Г | Б |
| 35 | Г | А | Г | Г | А |
| 36 | А | Г | А | А | Г |
| 37 | А | В | Б | А | В |
| 38 | Г | А | Б | Г | А |
| 39 | Г | А | В | Г | А |
| 40 | Б | Б | В | Б | Б |